



Есүс: “Тэнгэрт дээш гарсан хүн нэг ч байхгүй”

Өмнөх хэдэн нийтлэлд үхэл ямар ч амьгүй байдлыг хэлдэг гэж нотлох Библийн олон ишлэлийг харуулсан. Гэтэл энэ ойлголттой зөрчилдөх мэт хэд хэдэн Библийн хэсэг байдаг. Жишээ нь, Есүсийн дүр хувирахад Түүний хамт үзэгдсэн Мосе, Елиа хоёрыг, эсвэл Есүсийн дэргэд цовдлогдсон гэмт хэрэгтнийг дурдаж болно.

Хэрэв үхэл амьгүй байдлыг хэлдэг нь үнэн юм бол үүнтэй зөрчилдөх бүх тохиолдлыг тэр үнэний дагуу тайлбарлах тайлбар байх ёстой. Эдгээрийг энэ нийтлэлд авч үзэх болно.

1. Елиа тэнгэрийн улсад байхгүй нь лавтай “Елиа амьдаараа тэнгэр явсан” гэж заах нь түгээмэл. Учир нь, “Елиа хуй салхиар тэнгэр өөд одов. Елиша... Елиаг дахин харсангүй” (Хаадын дэд 2:11).

Сонирхолтой нь, Мөнхийн Эзэний Сүнс Елиаг өмнө нь ч тэнгэр өөд өргөж, өөр газар аваачсан бололтой (Хаадын дээд 18:12; Хаадын дэд 2:16).

Ямартай ч, тавин эш үзүүлэгч Елиаг тэнгэрийн улсад бүр явсан гэж бодоогүй, харин түүнийг олно гэж бодоод тавиулаа гурван өдөр эрж хайсан.

Гэвч энэ удаад тэд Елиаг олж чадаагүй.

Елиа тэдэнд олдоогүй нь түүнийг зайлшгүй тэнгэрийн улсад явсан гэсэн үг гэж үү? Үгүй ээ.

Елиша Елиатай дахин уулзаагүй нь түүнийг яалт ч үгүй тэнгэрийн улс явсан баталгаа бас биш.



Тэнгэрт дээш гарсан хүн нэг ч үгүй □ 2

Библийн “тэнгэр” гэсэн үгэнд тэнгэр дээрх улсаас гадна мэдээж одод гялалзах, жигүүртэн шувуудын нисдэг орон зай ч багтдаг билээ (Эхлэл 7:3).

Елиа тэнгэр өөд одоход хуй салхитай байсан учраас цаг агаар явагддаг тэр тэнгэрийг ярьж байгаа нь ойлгогдож байна.

Бид өнөөдөр онгоцоор аль тийшээ нисэхдээ мөн адил “тэнгэр өөд оддог” бөгөөд ард үлдээсэн хүмүүс биднийг (эргэж ирэхгүй л юм бол) “дахин харахгүй”. Гэхдээ бид заавал хаана нэг газарт буух учиртай.



Яг ийм явдал бас «Шинэ Гэрээ»-ний үед болсон. “Эзэний Сүнс Филиппийг авч одов. Тайган түүнийг дахин олж хараагүй”. “Дахин хараагүй” гэдэг нь Филиппийг тэнгэрийн улсад очсон гэсэн үг биш, тэрээр Азот гэдэг дэлхий дээрх өөр газар дахин “олдсон” (Үйлс 8:39-40). Елиа ч гэсэн тухайн үед өөр газар буусан байж таарна.

Ямартай ч, Елиа үйлчлэлээ үргэлжлүүлсэн баталгаа Библид бий. Тухайлбал, арваад жилийн дараа Иуда улсын Иехорам хаанд Елиагийн бичсэн захидал ирдэг (Шастирын дэд 21:12). Энэ захидалд Елиа, Елиша хоёрыг салсан тэр өдрөөс хойш хэдэн жилийн дараа л болсон явдал дурдагдсан юм.




Тэнгэрт дээш гарсан хүн нэг ч үгүй □ 3

Улмаар, Елиагийн энэ гайхалтай аялалаас олон зуун жилийн дараа Есүс түүнийг тэнгэрийн улсад очсон үгүйг илчилсэн тодорхой үг хэлэв.

Үүнд: **“Тэнгэрээс доош бууж ирсэн Хүний Хүүгээс [=Есүсээс] өөр тэнгэрт дээш гарсан хүн нэг ч байхгүй”** гэжээ (Иохан 3:13). Есүс Их Эзэний энэ үг дэндүү тодорхой. Та Их Эзэний

маань үгэнд итгэвэл Елиа тэнгэрийн улс явсан эсэх асуултанд хэрхэн хариулахаа мэдсэн байна.



2. Мосе ба Елиа хоёр Петрт үзэгдсэн нь

“Есүс гурван дагалдагчаа дагуулан өндөр уулан дээр гарч тэнд өөрийн үеэсээ олон зуун жилийн өмнө амьдарч байсан Мосе Елиа хоёртой уулздаг. Тэр хоёр хаа нэг газарт амьд байдаг гэсэн үг” гэж олон хүн тухайн түүхийг барьж учирладаг.

Библийг дутуу уншихаар буруу ойлголт гарч ирэх нь олонтаа. Энэ тохиолдолд мөн адил. Анхааралтай уншвал “Мосе, Елиа нар Түүнтэй ярилцаж байгаа нь тэдэнд **үзэгдэв**” гэж Библид бий. Дараа нь тэр уулнаас бууж явахад Есүс “энэ **үзэгдлийг** хэнд ч бүү хэл” гэж тэдэнд анхааруулдаг (Матай 17:3,9).



Энэ нь Үйлс 10-т Петрийн үзсэн, эсвэл «Илчлэл» номд Иоханы үзсэн “харилцан явагдах үзэгдэл” шиг ирээдүйг харуулсан зөгнөлийн чанартай үзэгдэл болохоос, болсон явдал биш.



Моше, Елиа хоёр

үзэгдсэн ч, Есүстэй ярилцсан ч, үнэн хэрэгтээ амьдаар нь тэнд байгаагүй гэсэн үг. Тэдний тэр үед ба өнөөг хүртэл булшиндаа амарч буйг бид Библийн өөр олон ишлэлээс дүгнээд баттай хэлж чадна.

3. Самуел нас барсныхаа хойно Саулд үзэгдсэн нь “Саул Эндор хотын сүнс дуудагч эмийг эргэхэд Самуел түүнд үзэгдсэн (1 Самуел 28:15). Энэ нь Самуелыг нас барсныхаа хойно ч Үхлийн ертөнцөд амьд болохыг харуулна” гэж үздэг итгэгч олон бий.

Сүнс дуудагч эмийн дуудсан Самуел зөвхөн үзэгдэл байсан байж таарна. Эсвэл хоёрдахь боломжит тайлбар ч бий. Үүнд: Саулд үзэгдсэн сүнс үнэндээ Самуел биш, харин муу ёрын сүнс байв. Тийм бол энэ тохиолдолд худал хэлээгүй, Ертөнцийн Эзэн муу ёрын сүнсээр хүртэл үгээ дамжуулж чадалгүй яхав.



Өнөөдөр сүнс дуудагч дээр очсон хүмүүс мөн адил хий үзэгдэл харж, яг л Их Эзэнээс ирсэн гэмээр тийм ноцтой үгийг хүлээн авдаг. Гэвч дуудагдсан сүнс нь тэдний хүссэн хүний сүнс мөн гэж итгэх хэрэггүй, бас тийм сүнс үнэнг хэлнэ гэж бодох



хэрэггүй. Муу ёрын зальтай сүнс үхэгсдийг амьд байхад нь маш сайн мэддэг байсан бөгөөд дүрээр нь тоглох авъяастай гэж мэдэх нь чухал. Тиймээс ч Библид үүнийг хориглосон нь учиртай. Хэрэв бид Дэд хууль 18:9-12-т тэмдэглэсэн, Их Эзэний тодорхой хэлсэн хориглолтыг зөрчиж, сүнс дуудагчийг эргэх юм бол олигтой юм болно гэж бодох хэрэггүй. Улмаар, энэ талаарх алдарт герман яруу найрагч Гётегийн үгийг бодох нь зүйтэй. Үүнд:

“Дарамт зовлон яасан их байна!

Дуудсан сүнснээсээ салж чадахгүй байна!”

Та өөрөө мэдээрэй. Үхэгсэд хаа нэг газарт амьд байдгийг баталсан, шулмын дуудсан сүнсэнд итгэх үү? Эсвэл үхэгсдийг булшинд амьгүй хэвтэж байгааг тод хэлсэн Бүтээгч Эзэний үгэнд итгэх үү?



4. Есүсийн дэргэд цовдлогдсон гэмт хэрэгтэн диваажинд орох болоогүй

“Есүс хажууд нь цовдлогдсон нэг гэмт хэрэгтэнтэй тэр л өдөр хамт диваажин байхаар амласан нь ямар учиртай вэ?”

Энэ асуултын хариу нь ердөө цэс, таслал хаана тавихтай холбоотой. Грек эхэнд анх цэг таслал байдаггүй байсан. Иймд “Есүс ээ, Та Өөрийнхөө хаанчлалд ирэхдээ намайг санаарай” (Лук 23:42) гэж гуйсан тэр хүнд өгсөн Есүсийн хариуг хэлзүйн талаас авч үзвэл хоёр янзаар орчуулж болдог. Есүс яг юу хариулсныг хамтдаа грекээр болон дор нь тавьсан монгол хадмал орчуулгаар үзье. Гол үг нь “өнөөдөр”. Үүнд:

43 καὶ εἶπεν αὐτῷ ὁ Ἰησοῦς Ἀμήν λέγω
43 Тэгтэл гэлээ түүнд (-) Есүс Үнэнээр Би-хэлье
(=Амен)
σοι σήμερον μετ' ἐμοῦ ἔσῃ ἐν τῷ παραδείσῳ
чамд өнөөдөр Надтай хамт чи-байх- Диваажин-д
болно


АБ олон улсын уламжлалыг дагаж энэ ишлэлийг ийн орчуулсан (1): “Тэгтэл Есүс түүнд -Үнэнээр Би чамд хэлье. **Өнөөдөр** чи Надтай хамт Диваажинд байх болно гэлээ”.

Цэгийг хаана тавьсныг нь анхаараарай: “Өнөөдөр” гэсэн үгийн өмнө.

Грек эхэнд цэг, таслал байгаа эсэхийг та шалгаарай. Байхгүй. Грек хэл МЭ 9-р зуун хүртэл цэг тэмдэглэл хэрэглэдэггүй байсан учраас тэр. Том, жижиг үсгийг



ч ялгадаггүй байв (эхлээд дан том үсгээр, дараа нь дан жижиг үсгээр бичих янз маягтай байлаа). Нэгэнт цэг цэглэл байхгүй учраас Есүсийн өнөөх гэмт хэрэгтэнд хэлсэн үгийг бас ийн орчуулж болдог (2): “Үнэнээр Би чамд хэлье **өнөөдөр**. Чи Надтай хамт Диваажинд байх болно.” Энэ хувилбард цэгийг “өнөөдөр” гэсэн үгийн дараа нь оруулсан биз? Тэр ганц цэгийг хаана оруулснаас болж утга нь хэрхэн өөрчлөгдөхийг анзаараарай. Гол үг нь “өнөөдөр”. Хэрэв цэг нь “өнөөдөр” гэдэг үгийн наана орвол Есүс тэр л өдөр диваажин орохыг бодно (1-р боломжийн орчуулга). Харин цэг нь “өнөөдөр” гэдэг үгийн цаана орвол Есүс ирээдүйд биелэх энэ амлалтаа өнөөдөр өгч байгаа гэсэн үг (2-р боломжийн орчуулга).



Энэ хоёр орчуулгын аль нь зөв байхыг шийдэхэд еврей хэллэгийн тухай мэдэх нь ч тустай. Тухайлбал: еврейчүүд үгээ батлах гэж “өнөөдөр танд хэллээ” гэсэн хэллэг хэрэглэдэг байв (жишээ нь, Иеремиа 42:21). Энэ ишлэлийг хэрхэн цэглэхийг грек эх нэгэнт зааж өгөөгүй учраас уншигч та өөрөө шийдэж болно гэсэн үг. Есүсийн хэлсэн энэ үг үхлийн тухай бусад Библийн үгтэй нийцэх ёстой юу, үгүй юу? гэдэг асуулт танд ингээд тавигдлаа.



Хэрэв та “тийм” гэж хариулвал хоёрдугаар хувилбар зөв болох нь ойлгомжтой.

Гэтэл үүгээр ч барахгүй, энэ явдал үхлийн тухай сургаалаас гадна мөн “Диваажин”, “Есүс ирэх”, “эш үзүүлэлт”, “Ертөнцийн Эзэний байгуулах Хаант улс” гэх мэт бусад сэдвийг хөндөнө.

Диваажин бол тэнгэрт биш, энэ дэлхий дээр мянган жил цэцэглэх тэр Хаант улсыг хэлнэ¹. Абрахам, Мосе, Давид зэрэг итгэлийн баатрууд өдий хүртэл Их Эзэний өөрсдөд нь амласан тэр улсад ороогүй хэвээр (Еврей 11:39-40).

Тийм байхад Есүстэй хамт цовдлогдсон гэмт хэрэгтэн юу гэж тэдний урдуур орох вэ?

Бас өөрөө нас барсан хойноо биегүй байх нь бүү хэл, байгуулагдах болоогүй газарт хэрхэн очих вэ? Боломжгүй!

1 Лук 23:43-т гардаг “диваажин” гэж орчуулсан грек үг (παράδεισος, paradise) перс гаралтай бөгөөд “цэцэрлэг” гэсэн утгатай (Нехемиа 2:8, еврей: פַּרְדֵּי, пардес; АБ: “ой”). Энэ үг Есүсийн хэрэглэдэг байсан «Хуучин Гэрээ»-ний грек орчуулганд («Септуагинта») анх Ээдэн цэцэрлэгийг хэлсэн (Эхлэл 3:2 г.м.). Ирээдүйн мянган жилийн Хаант Улс ба үүний дараах Шинэ дэлхий яг тийм сайхан, цэцэглэсэн диваажин байх болно (Дуулал 67:4,6-7; 72:1-17; Исаиа 4:2; 30:23,24; 35:1,2,5,6; 41:18,20; Иеремиа 31:5,12; Езекиел 34:25-27, 36:29,30, 47:8,9,12; Хосеа 2:18,21,22; Иоел 3:18; Амос 9:13-15; Зехариа 8:12; Илчлэлт 2:7; 22:2). Диваажин бол тэнгэрийн улс биш, шинэчлэгдсэн буюу шинээр бүтээсэн дэлхий гэсэн үг. Энэ нь mongoltoli.com-н дагуу монголчуудын ч диваажинд өгсөн шилжсэн утгын хэрэглээнд нийцэх юм. Үүнд: “Хүний аж төрөхөд ая тухтай нөхцөл бүрдсэн орчин газар, жаргалын орон.”



Тэнгэрт дээш гарсан хүн нэг ч үгүй □ 9

Тэгсэн ч гэсэн Есүс хамт цовдлогдсон тэр хүндээ Диваажинд орох амлалт өгсөн. Энэ мөн учиртай. Тэр хүн өөрийгөө цаазын ял авах ёстой ч, Есүсийг цаазлуулахаар

хэрэг юу ч хийгээгүйг мэдсэн. Үүнээс гадна эш үзүүлэгч нарын зөгнөсөн Машиах Хаан ирж, эрт дээр үеэс амласан Хаант Улсаа байгуулах ёстой гэсэн ойлголт түүнд байсан. Есүс Ертөнцийн Эзэний илгээсэн тэр Хаан мөн гэдэгт тэр хүн сая итгэлээ (Лук 23:38-42).



Түүний хийсэн олон гайхамшгийн тухай гарцаагүй сонсож байсан (Үйлс 2:22; 26:26), одоо биеэ загалмай дээр хэрхэн авч явж байгааг нүдээрээ харсан учраас тэр биз ээ (жишээ нь, Лук 23:34).

Ямартай ч, Есүсээс гуйсан гуйлт нь үнэхээрийн гайхалтай итгэлийг харуулж байна.

Гуйлтыг нь биелүүлэхийн тулд Есүс заавал дахин амилж, Хаант улсаа байгуулж хаанчлалыг гартаа авах ёстой. Ялангуяа Түүнийг загалмайд өрөвдөлтэй нь аргагүй цовдолсон байхыг нүдээрээ



Тэнгэрт дээш гарсан хүн нэг ч үгүй □ 10


харж байхдаа Хаан гэж харах нь үнэхээрийн агуу итгэл юм.

Яг тэр итгэл агуулсан гуйлтад Есүс хариулахдаа тэр хоёрын загалмайд цовдлогдсон тэр өдрийг яриагүй. Харин ирээдүйн Хаант Улсын диваажинд жаргах болно гэдгийг тэр өдөр түүнд баттай амалсан билээ.

5. Алуулсан итгэгчдийн сэтгэл Тэнгэрийн улсын тахилын ширээн доор үзэгдсэн нь

Их Эзэний Үгийг гэрчилдэг байсныхаа төлөө алуусан итгэгчдийн олон сэтгэлийг² Иохан харсан билээ (Илчлэл 6:9-11; АБ: “сүнснүүд” гэсэн нь

буруу!). Тахилын ширээн доор буй тэргээр сэтгэлүүд урсгасан цусныхаа төлөө өшөө авахыг Их Эзэнээс шаардан хашгирдаг. Тэгэхэд тэдэнд цагаан дээл өгч, дахиад түр амрах хэрэгтэй гэж хэлдэг.



Энэ хачирхалтай үзэгдлийг зарим нь болсон явдал мэтээр хүлээн авч, “*тэнгэрт хүмүүс сүнсээрээ юмуу сэтгэлээрээ байдаг*” гэж ойлгодог. Тэгвэл энэ үзэгдлийг шууд утгаар нь ойлгох ёстой бол тэнгэрт

2 Грек: “психе”, психологи буюу сэтгэлзүйтэй харьцуулна уу.



буй хүмүүс цус дүүрэн өмхий үнэрт нүхэнд шахалдаад сууж байна гэж ойлгоход хүрнэ. Ийм муухай тавилан Их Эзэний төлөө амь насаа өргөсөн хүний шагнал биш байлтай. Бас тийм газар цагаан дээл өмсөх хэрэг юу байх билээ?

Үгүй, энэ үзэгдлыг бэлгэдлийн чанартай гэж ойлгохоос өөр аргагүй.

Тэгвэл эдгээр сэтгэл “тахилын ширээн доор” байгаа нь юуг илэрхийлэх вэ?

Үүнийг ойлгохын тулд хэд хэдэн баримтыг цуглуулах хэрэгтэй. Тухайлбал:

1. Соломон хааны барьсан сүмийн тахилын ширээн доор, нядалсан өргөлийн амьтдын цус асгадаг гүнзгий нүх байсан (Левит 4:7-н зааврын дагуу).

2. “Бие махбодын **сэтгэл цусанд** байдаг” билээ (Левит 17:11; АБ “амь” гэсэн нь буруу!).

Энэ хоёр баримтыг харвал, тахилын ширээн доорх “сэтгэлүүд” итгэгчдийн цусаа өргөл мэт асгасныг нь дүрсэлдэг хэмээн ойлгогдож байна.

Улмаар:

3. Ахдаа алуулсан Абелийн цус газраас Их Эзэн лүү “хашгирдаг” байсан (Эхлэл 4:10, Еврей 12:24).

Үүнчлэн энэ алагдсан сэтгэлүүд (буюу тэр итгэгчдийн цус) өшөө шаардан “хашгирдаг”.

Абелийн цусанд хашгирч чадах бодит ам хэл байгаагүй нь мэдээж. Эдгээр сэтгэлийн хашгирч буйг тэр дүрслэлтэй адил гэж ойлговол яг таарна.

Тэд дахиад жаал “амрах” хэрэгтэй гэсэн нь үхэгсдийн нойрсохыг хэлсэн бөгөөд тэдний дахин



амилах нь хараахан болоогүйг илэрхийлсэн юм.

6. Биеэсээ холдон явах нь Их Эзэнтэй хамт байхыг хэлэх үү?

Паул **“биеэсээ холдон явж, Эзэнтэй хамт гэртээ байх нь хавьгүй дээр”** гэж үздэг байв (2 Коринт 5:8). Олон хүн энэ үгийг **“биеэсээ холдох буюу үхэх нь Есүстэй хамт байхыг хэлнэ”** гэж ойлгодог.



Сайтар уншвал, Паул энэ дэлхийгээс явж, Есүстэй хамт байх хүслээ л илэрхийлж байгаа нь тодорхой болохоос итгэгч хүн үхэхдээ шууд Есүс дээр очно гэж хэлээгүй. “Замын бөглөрөө дүүрэн Улаанбаатараас явж, Дарханд байх нь хавьгүй дээр” гэж хүний хүсч хэлснийг “Улаанбаатараас явах нь Дарханд байна гэсэн үг” гэж ойлгож болохгүй нь мэдээж. Үүнчлэн биеэсээ хагацахыг шууд л тэнгэр дэх улсад байхтай адилтгаж болохгүй.

Хэл зүйн дүрэм ямар ч өгүүлбэрийг зөв ойлгохын тулд оршин байдаг. Тийм учраас ялангуяа Ертөнцийн Эзэний өгсөн үгийг зөв ойлгоё гэвэл хэлзүйн дүрэмд хайхрамжгүй хандан, хамаагүй



зөрчиж огт болохгүй. Их Эзэний үгэнд бид хайнга биш, харин нарийн нямбай хандах хэрэгтэй.

Дүгнэж хэлэхэд, Ертөнцийн Эзэний Үгэнд үхлийн талаар утга нь тодорхой маш олон мэдээлэл өгсөн байдаг. Энэ сэдвийн талаар Бүтээгч Эзэн хамгийн сайн мэдэх нь гарцаагүй. Тэрээр үхлийг амьгүй байдал гэж хэлсэн бол тийм л байна. Олонтоо тодорхой хэлсэн үнэнийг нь байгаагаар нь хүлээн авч, бат итгэх нь зүйтэй. Тэгээд тодорхойгүй юмуу зөрчилдөх мэт санагдах зүйл тааралдвал тэрний тайлбарыг тод хэлсэн үгийн заасан хязгаарын дотор эрж хайх нь ухаалаг юм. □

Дараагийн нийтлэлд “үхлийг үзэлгүй дээш аваачигдсан” боловч мөнх бусаа үзүүлсэн Енохын нууцлаг түүхийг авч үзэх болно.

Хэрэглэсэн эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон.

---Gill, J. (1763). *Exposition of the Old and New Testaments*.

<https://www.biblestudytools.com/commentaries/gills-exposition-of-the-bible/>

---Монгол Хэлний Их Тайлбар Толь (2016). mongoltoli.mn

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон.

---Strong, J. (1890). *Strong's exhaustive concordance of the Bible* (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org